



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ноён сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2023/104/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Өмнөговь аймаг

2023 он

Хаан консалтинг аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал:

Ч.Баярсайхан

Утас: 89000060 Цахим хаяг: bayaraach85@gmail.com

Аудитын менежер: Г.Ганцэцэг

Утас: 88883775 Цахим хаяг: jni.gantsetseg@gmail.com

Ахлах аудитор: Э.Нандинчимэг

Утас: 88883776 Цахим

хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.08.24 № 76

танай _____-ны № _____-т

НОЁН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ Ц.СҮРЭНЖАРГАЛ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мандал-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Ноён сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 236.2 сая төгрөгийн зөрчил илэрч тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн "Тохиолдсон байх", "Үнэн зөв байдал", "Толилуулга ба тодруулга", "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант хугацаанд Эрүүл мэндийн газраас үнэ төлбөргүй бараа материал болон үндсэн хөрөнгийн дэмжлэг үзүүлсэн нь эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаандаа зарцуулах эргэлтийн хөрөнгө болон эргэлтийн бус хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Нийгмийн даатгалын тайланд 20.1 сая төгрөгийн цалин тайлагнаагүй байна.

016020121

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБӨУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБЯЯР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	236,401.7	170,851.0
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,744,736.1	2,140,005.6
Нийт хөрөнгийн дүн	1,981,137.8	2,310,856.6
Нийт өр төлбөрийн дүн		-
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,981,137.8	2,310,856.6
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,981,137.8	2,310,856.6
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	1,372,873.2	1,444,679.8
Үйл ажиллагааны зардлын дүн	1,127,196.3	1,117,380.9
Үйл ажиллагааны үр дүн	245,676.9	327,299.0
Үйл ажиллагааны бус үр дүн	-	(3,580.3)
Үйл ажиллагааны нийт үр дүн	245,676.9	323,718.7
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	100,223.8	99,459.0
Тайлант оны үр дүн	118,261.4	321,250.8
Эцсийн үлдэгдэл	1,981,137.8	2,308,388.6
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,057,826.1	949,272.7
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	925,570.4	880,126.7
Үйл ажиллагааны ЦМГ	132,255.7	69,146.0
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(31,110.0)	(71,703.7)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	101,145.7	(2,557.7)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	5,007.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,450.0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,178,617.4	951,830.4
Урсгал зардал	1,178,617.4	951,830.4
Хөрөнгийн зардал	-	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	950,211.7	949,272.7
Улсын төсвөөс санхүүжих	-	-
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	42,930.0	42,930.0

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 236.2 сая төгрөгийн алдаа илэрснээс, аудитын явцад 236.2 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг илрүүлж, баталгаажуулав. Үүнд:

- 2022 оны цалингийн бүртгэлийг тооцож үзэхэд 27 ажилтны 20.1 сая төгрөгийн цалинг НД-ын тайланд тайлагнаагүй.
- Бараа материалын дансны үлдэгдлийг тооллогын бүртгэлтэй тулган баталгаажуулахад 216.0 сая төгрөгийн бараа тооллого хийж баримтжуулаагүй.

Залруулагдаагүй 2 зөрчлийн дүн 236.2 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 11.8 сая төгрөгөөс хэтэрсэн тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт өгөгдөөгүй болно.

Албан шаардлага

1. Бараа материалын дансны үлдэгдлийг тооллогын бүртгэлтэй тулган баталгаажуулахад 216.0 сая төгрөгийн бараа тооллого хийж баримтжуулаагүй.
2. 2022 оны цалингийн бүртгэлийг тооцож үзэхэд 27 ажилтны 20.1 сая төгрөгийн цалинг НД-ын тайланд тайлагнаагүй зэрэг зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Зөвлөмж

Шатах тослох материалын зарцуулалтыг хянаж олгохдоо Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 12 сарын 30-ны №390 дугаар тушаалыг мөрдөх талаар зөвлөмж хүргүүлсэн.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	/сая төгрөгөөр/ Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТШЗ	2	236.2			2	236.2						
Дүн	2	236.2			2	236.2						

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ						1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ						1		